



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 403.

Улаанбаатар хот


Дэн буудлын зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 7.7.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрчлөгдсөн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах "ДОЖ" ХХК-ийн "Титэм" дэн буудлын 13/197 тоот, Баянгол дүүргийн 9 дүгээр хороонд байрлах "УТУ" ХХК-ийн "Хан" дэн буудлын 13/188 тоот, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах иргэн Д.Сэдбазарын "Наран-Мандал" дэн буудлын 13/194 тоот, Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд байрлах "Цэцэнхангай" ХХК-ийн "Хүннү" дэн буудлын 13/281 тоот зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА